

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН ГОТОВ ОВОГТОЙ СҮРЭНЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлийн хувь			
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)						
1	2	3	4	5	6	7					
Зорилт 1. “ЗГҮАХ-ийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3-28 ”											
1.	<p>Арга хэмжээ 1.1. Судлагдахууны багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг сайжруулах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах</p> <p>/ЕБС-ын биеийн тамир багш нар хамрагдана./</p> <p>Хамтарч ажиллах байгууллага:ХБХСЗХТ</p>	<p>Арга хэмжээний тоо;</p> <p>Хамрагдсан хүний тоо;</p> <p>Удирдамж, сургалтын хөтөлбөр батлуулах,</p>	1	1	30	30	1	1	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Баянгол дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисстой хамтран сургуулиудын биеийн тамирын багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг сайжруулах, сургалтад ашиглаж буй хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжтэй танилцах, мөн хүүхдийн төвийн болон тусгай сургуулиудын биеийн тамирын багш нарын шинэлэг бүтээлч санал</p>	<p>2024.11.01</p> <p>2024.11.21</p>	

					<p>санаачлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор туршлага солилцох 2 кредитын сургалт, уулзалтыг 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд зохион байгууллаа.</p> <p>Сургалтад Баянгол дүүргийн сургуулиудын биеийн тамирын багш нар, Нийслэлийн ерөнхий боловсролын 25, 29, 55, 63, 70, 116 дугаар сургуулиудын биеийн тамирын 50 гаруй багш нар хамрагдлаа.</p> <p>Сургалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, ур чадварыг сайжруулах мэдээллүүдийн хүргэхийн зэрэгцээ харилцан суралцах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад тулгарч буй асуудал, бэрхшээлд дүн шинжилгээ хийж авч хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх талаар санал солилцож, тус төвийн ерөнхий бүтэц, менежмент, үйл ажиллагаатай танилцан үр дүнтэй сургалт болж өндөрлөлөө.</p> <p>Цаашид энэхүү сургалтыг нийслэлийн бусад дүүргүүдтэй хамтран зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>		
2	Арга хэмжээ 1.2.	Арга хэмжээний тоо;	1	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын 2024 оны 10	2024.09.25	

	<p>ХБХСЗХТ-ийн ажилтан, албан хаагчдыг Хүүхэд хамгааллын чиглэлээр талаар чадавхжуулах арга хэмжээ зохион байгуулах</p> <p>Хамтарч ажиллах байгууллага: Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар</p> <p>Хамтарч ажиллах байгууллага: Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар</p>	<p>Хамрагдах хүний тоо;</p> <p>Удирдамж, сургалтын хөтөлбөр батлуулах,</p>	50	50	<p>дугаар сарын 01-ний өдрийн баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой мэдлэг мэдээлэл олгох зорилгоор “Хүүхдийн төвийн ажилтан, албан хаагчдыг хүүхэд хамгааллын чиглэлээр чадавхжуулах” сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр ХБХСЗХТ-ийн хурлын зааланд Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн хэрэгжилтийн газартай хамтран зохион байгуулсан.</p> <p>Сургалтад нийт хүүхдийн төвийн 58 ажилтан, албан хаагчид хамрагдсан бөгөөд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилт болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг хэрхэн үзүүлэх зэрэг мэдээллүүдийг хүргэж ажилласан.</p> <p>/Зарцуулсан төсөв-2,500,000 төгрөг/</p>	2024.10.01	
3.	<p>Арга хэмжээ 1.3</p> <p>Сургуулийн нийгмийн ажилтан, өрхийн эмнэлгийн нийгмийн ажилтан, сургуулийн сэтгэл зүйч нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга</p>	<p>Арга хэмжээний тоо;</p> <p>Хамрагдах хүний тоо;</p>	1	1	<p>Налайх дүүргийн хамран сургах тойргийн сургуулиудын нийгмийн ажилтнууд, сургуулийн сэтгэл зүйч, сургуулийн эмч нарт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээр хангах, чадавхжуулах сургалт”-</p>	2024.05.01 2024.05.03	

	<p>зүйгээрхангах чадавхжуулах, хүүхдийн төвийн үйл ажиллагаатай танилцуулах</p> <p>Хамтарч ажиллах байгууллага:ХБХСЗХТ</p>	<p>Удирдамж, сургалтын хөтөлбөр батлуулах,</p>			<p>ыг 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Налайх дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран зохион байгуулж 24-н ажилтан, албан хаагчид хамрагдлаа. Тус сургалтаар хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээр хангах, дэд бүтэц, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг мэдээллүүдийг хүргэж, Дохионы хэлний анхан шатны мэдлэгийг олгож, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалж ажиллалаа.</p>		
<p>Зорилт 2. ““ЗГҮАХ-ийн 3.3-р зорилтын 3.3.28-р заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 43-р тогтоол, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/109 дугаар тушаал, Боловсрол шинжлэх ухааны яамны сайдын 2021 оны 05 дугаар сарын13-ны өдрийн а/177 дугаар тушаал ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД”</p>							
1	<p>Арга хэмжээ 2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журмын хэрэгжилтийг хангах арга хэмжээ зохион байгуулах</p> <p>Хамтарч ажиллах байгууллага: -Боловсролын ерөнхий газар -ХБХСЗХТ</p>	<p>Арга хэмжээний тоо; Хамрагдсан хүний тоо; Уулзалт сургалтын тоо;</p>	- - -	1 45 1	<p>Боловсролын ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвтэй хамтран ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хэрхэн хамруулах талаар Налайх дүүргийн төрийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нартай мэдээлэл солилцох уулзалтыг 2024 оны 05 дугаар 03-ны өдөр, Чингэлтэй дүүргийн 83 дугаар</p>		

			<p>цэцэрлэгийн арга зүйч, багш нарт 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр тус тус зохион байгуулсан. Уулзалтад, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Хөгжлийн ерөнхий газрын харьяа Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Боловсролын ерөнхий газрын Тэгш хамруулах боловсролын хэлтсийн болон тэгш хамран сургах, эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан холбогдох газар, хэлтсийн мэргэжилтнүүд оролцож, 40 гаруй эрхлэгч, арга зүйч, багш нар хамрагдлаа.</p> <p>“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах журам”-ын хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчныг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээл, дэд бүтэц, хүртээмжийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр мэдээлэл солилцож ажилласан.</p> <p>Цаашид хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хөгжлийн онцлог арга хэрэгцээнд нийцсэн арга зүйн дэмжлэг үзүүлэхэд мэргэжлийн байгууллагатай</p>	<p>2024.03.20 2024.03.22</p>	
--	--	--	--	----------------------------------	--

					хамтран ажиллах шаардлагатай байгаа талаар оролцогчид онцолсон.		
2.	<p>Арга хэмжээ 2.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрт байгаа авьяас, чадвар нөөц боломжид тулгуурлан мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдралд бэлтгэх зорилгоор МБУЧОС, тусгай сургуультай хамтран “Мэргэжлээ зөв сонгоё” өдөрлөг зохион байгуулах</p> <p>Хамтарч ажиллах байгууллага: МУИС, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн газар, тусгай 6-н сургууль</p>	<p>Арга хэмжээний тоо;</p> <p>Хамрагдсан хүний тоо;</p> <p>Удирдамж, сургалтын хөтөлбөр батлуулах,</p>	1 50	1 50	<p>“Мэргэжлээ зөв сонгоё” өдөрлөгийг 2024 оны 04 дүгээр сарын 26-наас 05 дугаар сарын 14-ний хүртэлх өдрүүдэд зохион байгуулсан. Өдөрлөгт ЕБС-ын 25, 29, 55, 63, 70, 116-р сургуулийн төгсөх 9,12 дугаар ангийн 170 гаруй сурагчид хамрагдсан. Арга хэмжээнд мэргэжлээ хэрхэн зөв сонгох, мэргэжил сонгох алхамууд, ажил мэргэжлийн ялгаа, мэргэжил эзэмших ач холбогдол, карьер, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ зөв сонгоод амжилттай хөдөлмөр эрхэлж байгаа сайн туршлага зэрэг мэдээллийг хүргэсэн.</p>	2024.04.10 2024.05.14	
3.	<p>Арга хэмжээ 2.3 “Тэгш хамруулан хөгжүүлэх” чиглэлээр сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах</p> <p>Хамтарч ажиллах байгууллага: Боловсролын ерөнхий газар</p>	<p>Арга хэмжээний тоо;</p> <p>Хамрагдах хүний тоо;</p> <p>Удирдамж, сургалтын хөтөлбөр батлуулах,</p>	-	1 50 1	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийн онцлог хэрэгцээнд нийцсэн дэмжлэг үзүүлж тухайн хүүхдийг үе тэнгийн найз нөхөдтэй нь хамт суралцуулах боломжийг бүрдүүлэх, тэгш хамрагдалтыг нэмэгдүүлэх, боловсролын хүртээмж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх хандлагыг өөрчлөх зорилгоор ХБХХЕГ, Боловсролын ерөнхий газрын Тэгш хамруулах боловсролын хэлтэстэй хамтран “Боловсролд тэгш хамруулах нь” нөлөөллийн сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Багахангай, Налайх дүүргийн Ерөнхий</p>	2024.03.20 2024.03.22	

					боловсролын сургуулиудын захирал, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын эрхлэгч нарт зохион байгууллаа. Нийтдээ 14 сургуулийн захирал, 9 цэцэрлэгийн эрхлэгч, дүүргүүдийн боловсролын хэлтсийн мэргэжилтнүүд, Насан туршийн боловсролын арга зүйч, багш нар 50 гаруй хүн хамрагдлаа.		
Зорилт 3. “Нийгмийн хамгаалал”							
1	Арга хэмжээ 3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чиглэлээр сэргээн засах үйлчилгээ үзүүлдэг байгуулагуудад туршлага солилцох уулзалт, сургалт зохион байгуулах	Арга хэмжээний тоо; Хамрагдах хүний тоо;	1 15 1	1 15 15	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах үйлчилгээ үзүүлдэг Эрхэм нандин сувд ТББ, Ээлтэй ертөнц ТББ, Энэрлийн түүчээ ТББ, Хүслийн ордон цэцэрлэг Нарны хаан хүүхдүүд, ХБХСЗХТ зэрэг 8 байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж туршлага судлах уулзалтуудыг 2024 оны 01 сарын 14-ны өдөр Энэрлийн түүчээ ТББ-д, 10 сарын 22-ны өдөр Эрхэм нандин сувд ТББ-д нийтдээ 2 удаа зохион байгуулж 50 гаруй ажилтан, албан хаагч, мэргэжилтнүүд хамруулсан. Туршлага солилцох уулзалтад ХБХСЗХ-ийн төвийн дарга Б.Ууганцэцэг, С.Энхбат нар хамтран оролцож тус төвүүдийн үйлчилгээ, үнэлгээ, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлуудаар санал солилцож, туршлага судалж ажилласан.	2024.01.1 1 2024.10.2 2	

2	<p>Арга хэмжээ 3.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын талаарх хууль, дүрэм, журманд санал өгөх</p>	Санал өгсөн баримт бичгийн тоо: 2	1	2	<p>Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэгт “Боловсролын, эрүүл мэндийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төв ажиллуулж болно” гэж заасан байдаг.</p> <p>Энэ хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх төв”-ийн загвар боловсруулах журмын ажлын хэсгийн хуралд 2 удаа оролцож, саналаа 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр бичгээр хүргүүлж мөн хэлэлцүүлэгт оролцож саналаа давхар өгсөн.</p> <p>Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв комиссын дүрэмд саналаа 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр амаар болон бичгээр өгч ажилласан.</p>	2024.01.02 2024.02.20	
3	<p>Арга хэмжээ 3.3 Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн санал, гомдол, хэрэгцээг үндэслэн дугаарын хязгаарлалтгүй зорчих зөвшөөрөл олгох талаар холбогдох байгууллагад уламжлах, шийдвэрлүүлэх</p>	Зөвшөөрөл авсан иргэний тоо; Хүсэлт гаргасан албан бичгийн тоо;	605 605	600 600	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.6-д заасан байнгын асаргаатай хүүхдүүдэд эмчилгээ, сувилгаа өдөр тутам шаардлагатайгаас гадна эрүүл мэндийн үйлчилгээ байнга авч байдаг тул байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн санал, гомдол, хэрэгцээ, шаардлагыг үндэслэн дугаарын хязгаарлалтгүй зорчих зөвшөөрлийн бичгийг Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтран 2024 онд</p>	2024.01.10 2024.12.01	

					нийтдээ 675 эцэг, эхэд олгож шийдвэрлэсэн.		
4	Арга хэмжээ 3.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн талаарх амаар болон бичгээр ирүүлсэн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг хүлээн шийдвэрлэх,уламжлах,зөвлөгөө мэдээлэл өгөх	Хүлээн авсан албан бичгийн тоо; Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн тоо;	-	-	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн талаарх амаар болон бичгээр ирүүлсэн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг хүлээн шийдвэрлэх,уламжлах,зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Албан хэрэг хөтлөлтийн letter программд 83 мэдээлэл ирсэн.Үүнд: Ирсэн бичиг-22 Явсан бичиг-51 Өргөдөл, гомдол -10 Нийт 10 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж 30 гаруй иргэнд зөвлөгөө, мэдээлэл хүргэж ажилласан.	2024.01.01. 2024.12.30	

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Арга хэмжээ 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний аж байдлын судалгааны ажлын хэсэгт ажиллах	-	-	-	Ажлын хэсэг нь 2023-2024 оны 04 сар хүртэл хугацаанд нийтдээ ХНХЯ-ны хурлын танхимд 3 удаа, МУИС-ийн социологийн тэнхимд 2 удаа, ХБХХЕГ-ын хурлын өрөөнд 2 удаа нийт 6 удаа хуралдсан. Судалгааны аргачлалыг боловсруулан ажиллаж байна. Судалгааны аргачлал	2024.01.01 2024.05.30	

				<p>боловсруулахад нийт 64,940,000 төгрөгийн санхүүжилтийг олгож МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш нар болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дараах ТББ-уудаар гэрээлэн гүйцэтгүүлсэн.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш С.Мөнхбаатар, Г.Түмэннаст -Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байгууллагуудын Шүхэр нэгдсэн бодлого ТББ -Хөгжлийн бүс ТББ -Жанцэцэн НҮТББ -Хүний эрхэд суурилсан хандлага бүхий өөрийн орны онцлогт нийцэх судалгааны арга, аргачлал Model disability survey нь (MDS) Хөгжлийн бэрхшээлийн тархалтыг хөнгөн, дунд, хүнд хэлбэрээр тодорхойлох, тэдний хангагдаагүй хэрэгцээ, саад бэрхшээл, тэгш бус байдлыг хөгжлийн бэрхшээлийн түвшин тус бүрээр тодорхойлох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого тодорхойлоход туслах зэрэг 296 асуумжтай аргачлалыг 		
--	--	--	--	---	--	--

					боловсруулаад ажлын хэсгээс санал аваад эцэслэх шатандаа явж байна.	
2.	<p>Арга хэмжээ 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /хөтөлбөр/-ийн хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн удирдах албан тушаалтнуудын зөвлөгөөний ажлын хэсэг</p>	-	-	-	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01,02 дугаар тогтоолоор батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /хөтөлбөр/-ийн хүрээнд хэрэгжиж буй 7 үйл ажиллагааны санхүүжилт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хуваарилагдсантай холбогдуулан тус хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрхэн хэрэгжүүлэх, мэдээлэл солилцох, хамтарч ажиллах талаар удирдах албан тушаалтнуудад 2 өдрийн арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд зохион байгуулах ажлын хэсэгт ажилласан.	2024.04.01 2024.04.10
3.	<p>Арга хэмжээ 3. Аутизмын хүрээний эмгэгийг таниулах сарын аян</p>	-	-	-	Аутизмын хүрээний эмгэгийг таниулах сарын аяны хаалтын үйл ажиллагаанд оролцож 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөрлөгт оролцсон иргэдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын талаар мэдээлэл, зөвлөгөө хүргэж ажилласан. Нийтдээ 20 гаруй иргэдэд дээрх чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн.	2024.05.01 2024.05.02

4.	Арга хэмжээ 4. Сайн туршлага-2024 арга хэмжээний ажлын хэсэг	-	-	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөгжлийн төвийн үйл ажиллагааг сайжруулах, иргэд, үйлчлүүлэгчдэд сурталчлан таниулах, сайн туршлага нэвтрүүлэх, оновчтой санал, санаачлагыг дэмжих зорилгоор “Сайн туршлага -2024” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэгт ажилласан. /2024 оны 05 дугаар сарын 30-ний өдөр зохион байгуулагдсан./	2024.05.25 2024.05.30	
5	Арга хэмжээ 5. Ерөнхий газрын дотоодын тооллого хийх комиссын ажлын хэсэг	-	-	-	Агентлагийн даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/88 тушаал Ерөнхий газрын дотоодын тооллого хийх комиссын ажлын хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд эд хөрөнгийн дотоодын тооллого хийсэн.	2024.05.30 2024.06.06	
6	Арга хэмжээ 6. Ерөнхий газрын “Ёс зүйн дэд хороо”-ны бүрэлдэхүүнд ажиллах	-	-	-	Агентлагийн даргын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/12 тушаалаар Ёс зүйн дэд хороо байгуулагдсан. Тус ажлын хэсэгт ажилласнаар дараах ажлуудыг гүйцэтгэж ажилласан. Үүнд: -Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр-ийн төсөлд санал өгсөн. -Төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм, хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн сургалтыг ХБХХЕГ болон харьяа	2024.05.01 2024.05.18.	

					байгууллагуудад 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдөр ХНХЯ-ны 10 давхарт зохион байгуулсан. -"Ёс зүйтэй төрийн хаагч" эссэ бичлэгийн уралдааныг 2024 оны 05 дугаар сарын 06-17-ны хүртэлх хугацаанд зохион байгуулж 8-н илтгэлээс шалгаруулсан.		
7	Арга хэмжээ 7. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг шалгаруулах арга хэмжээний ажлын хэсэг	-	-	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/236 тушаал Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг шалгаруулах арга хэмжээний ажлын хэсэг ажилласан.	2024.11.07 2024.11.29	
8	Арга хэмжээ 8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил оролцоо 2024 чуулганы ажлын хэсэг	-	-	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил оролцоо 2024 чуулганы ажлын хэсэгт 2024 оны 11дүгээр сарын 29-ны өдөр ажилласан.	2024.11.20 2024.11.29	
9	Арга хэмжээ 9. Абилити экспо-2024 арга хэмжээ ажлын хэсэг	-	-	-	Абилити экспо-2024 арга хэмжээний ажлын хэсэгт 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдөр ажилласан.	2024.11.15 2024.12.01	
10	Арга хэмжээ 10. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтын ажлын хэсэг	-	-	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/248 тушаал Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтын ажлын хэсэгт ажилласан.	2024.11.18 2024.12.03	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт


Д/д				Гүйцэтгэлийн түвшин
-----	--	--	--	---------------------

	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.	Арга хэмжээ 1. Эрхлэх асуудлын чиглэлээр холбогдох байгууллагаас зохион байгуулж танхимын болон цахим сургалт, семинарт хамрагдах 1-с доошгүй сургалт/семинарт хамрагдах	1-с доошгүй сургалт/семинарт хамрагдах	2 удаа	2 удаа	Эрхлэх асуудлын чиглэлээр эхний хагас жилд дараах ажлын байран дээрх сургалтуудад хамрагдсан. Үүнд: Архивын ерөнхий газраас 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан “Албан хэрэг хөтлөлт” сургалт /2024.01.11./ -Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын газар ”Гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх сургалт /2024.05.21/ -Төрийн албаны зөвлөлийн цахим 7.4.10 цуврал сургалтууд /2024.01.01-2024.05.30/ -Байгууллагын эцэг, эхчүүд хүүхдүүдийн хамт Дижитал мастер сургалт /2024.05.08/ -Төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс	2024.01.01. 2024.12.30.	

				урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт /2024.05.24./ -Удирдлагын академийн Төрийн захиргааны Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2024.09.17-2024.12.27 хүртэлх хугацаанд хамрагдсан.		
2.	Арга хэмжээ 2. Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх Тодорхой хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаандаа ашигласан байх			Удирдлагын академийн Төрийн захиргааны Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж судалбал зохих 8 хичээлийн дагуу Төрийн албаны тухай хууль бусад холбоотой 10 гаруй хууль журмыг судалж үйл ажиллагаандаа ашиглаж байна.	2024.01.01. 2024.12.30	

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

 /Г.Сүрэнцэцэг/

(Нэр, гарын үсэг)

2024.12.10.

(Огноо)